



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 5/32

Хэрлэн сум

Хөдөлмөрийн гэрээг цуцалж, ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2, Соёлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.1, 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.1, 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Нийтийн номын сангийн захирал О.Анхбаяр нь ажлаас чөлөөлөгдөх өөрийн хүсэлтээ гаргасан тул 2017 оны 2 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээг цуцлан дуусгавар болгож албан тушаалаас нь чөлөөлсүгэй.

Хоёр. О.Анхбаяртай холбогдох тооцоог зохих хууль, журмын дагуу хийж дуусгахыг нягтлан бодогч /Ш.Гантуяа/-т даалгасугай.

Гурав. Нийтийн номын сангийн захирлын ажил хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Г.Лхагвахатан	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Мөнгөнзул	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Одонтуяа	-Нийтийн номын сангийн бичиг хэрэг

Дөрөв. Ажлыг 2017 оны 2 дугаар сарын 06-ны өдөр хүлээлцүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА